

## МОНГОЛЫН ХҮН АМЫН ӨСӨЛТИЙГ ДЭМЖИХ

/ПРОНАТАЛИСТ/ БОДЛОГО

(Жишээ ба асуудлууд)

MUCHIRA MURAGURI, Доктрант МУИС-ийн ЭЗС-ийн

Хүн Амын Сургалт Судалгааны Төвийн Зөвлөх

Монгол Улс 1996 онд төрөөс баримтлах хүн амын бодлогодоо хүн амын жилийн дундаж өсөлтийн түвшинг 1.8 хувиас бууруулахгүй байх зорилт тавьсан. Гэвч 2000 оны тооллогын байдлаар энэ нь 1.4 хувь болтлоо буурсан бөгөөд 1990-ээд онууд дахь өсөлтийн хурдны бууралттай холбоотой юм. Хүн амын өсөлтийг дэмжих бодлогын зорилгын биелэлт нь хэрэгжилтийнхээ явцад хэд хэдэн бэрхшээлтэй болон маргаантай асуудлуудтай тулгараад байна. Өнгөрсөн зуунд дэлхийн нэлээд хэдэн улс орон хүн амын өсөлтийг дэмжих бодлогыг туршаад байгаа бөгөөд ямар нэг амжилтанд хүрээгүй байна. Хүн амын бодлого нь аль хэдийн хэрэгжээд байгаа болон одоо хэрэгжиулж байгаа улс орнуудын аль алиных нь хувьд анхаарлаа хандуулах шаардлагатай хэд хэдэн бэрхшээлтэй тулгамдсан асуудал бий болоод байгаа юм. Зарим улс орнууд ололт амжилттаа өөрсдөө бодлого боловсруулалтын явц дахь суп талаас үүдсэн үр дүнгээрээ хязгаарлаад байна. Тэдгээр нь бодлогоо албан ёсоор батлахаас өмнөх бэлтгэл ажлаа гол төлөв хангатгүй хийсэн байдаг. Бодлого боловсруулагдахаас өмнө зарим нэг шалтгаанууд тухайлбал, улс төрчид, төрийн хүнд сурталтангууд болон олон нийтийн хоорондын үл ойлголцох байдал, мөн хамгийн сайн үр дүнд хүргэх бодлогын хэмжүүрүүд дутагдсанаас сул дорий дэд бүтцийг бий болгож буй засгийн газрын шаардлага хангаагүй бодлого зэрэгтэй холбоотойгоор хүн ам зүйн болон бодлогын шинжилгээ нь хангатгүй түвшинд байдаг. Энэхүү өгүүлэлдээ ямар нэгэн шийдлийг санал болгохгүйгээр Монголын нөхцөлд дээрхи асуудлуудын заримыг авч хэлэлцэхийг мэрийлээ. Ирээдүйд бодлогыг илүү боловсронгуй болгох, хэрэгжүүлэх тал дээр бодлого боловсруулагчид болон бусад хүмүүс илүү хашир хандах болно гэдэгт гол найдварыг өгч байна. Энэхүү ажил нь өсөлтийг дэмжих маш оновчтой бодлогуудыг, товчоор хэлбэл нацист Герман болон Францын хүн амын өсөлтийг дэмжих бодлогын биелэлтийн талаар авч үзэх болно.

**“Францын хүн амын өсөлтийг дэмжих бодлого: Дэлхийн I дайны дараа Францын хүн амын бүтэц нь маш олон залуу эрэгтэйчүүдийг тулалдааны талбарт алдсанаас сул дорий болсон юм. 1920 онд жирэмснээс хамгаалах бүх хэрэгслийг хориотой болгожээ. Франц улс нь XXI зуунаас өмнө 100 сая хүн амтай болохыг хүсэж байв.**

1995 онд төрөлтийн нийлбэр коэффициент (ТНК) нь 1.8 байсан бөгөөд 2000 онд ялимгүй өсөж 1.9 болжээ. Хэтийн тооцоогоор энэ нь 2025 онд 1.8 болох төлөвтэй байна. З дахь хүүхдээ төрүүлж буй хосуудад 1064 Фунт стерлингийг жирэмсний амралт болон хүүхдийн тэтгэмжид зориулан олгох, жирэмсний амралтыг 6 сар болгох, З-аас дээш хүүхэдтэй өрхүүдэд нийтийн тээврийн унааны хөлсийг 30% хямдруулах, татварын хөнгөлөлт, улсын орон сууцны хуваарилалтанд хөнгөлөлт үзүүлэх зэрэг урамшууллын хэлбэрүүдийг ашиглаж байна.

Эхчүүд, гэрийн эзэгтэй нарт, мөн хүүхдийг хөгжүүлэх бодлого, хүүхдээ асарч буй эхчүүдийг хагас цагаар ажиллахыг нь дэмжих зэрэг тэтгэлгийн тогтолцоонууд байдаг.”, (Америкийн Тооллогын товчоо, 2003). Эндээс Монголын нөхцөлд юуг нь авч хэрэгжүүлэх боломжтой вэ?

## **ӨСӨЛТИЙГ ДЭМЖИХ ПРОНАТАЛИСТ БОДЛОГЫН ШАЛТГААН/ ҮНДЭСЛЭЛ**

Хөгжингүй хэд хэдэн улсууд ялангуяа, 1930 болон 1970-аад онуудад төрөлт нь эргэн нөхөгдөх түвшингээс доогур түвшинд тогтвортой байгаа улс орнуудад өсөлтийг дэмжих бодлогуудыг цаг хугацааны ялгаатайгаар авч үзэж байжээ.

Төрөлтийг хянах аргуудыг ашиглах боломжийг хязгаарлах, төрөлтийг нэмэгдүүлэхэд зориулсан санхүүгийн урамшуулал, олон хүүхэд төрүүлэх нь улс орны хувьд сайн хэрэг гэсэн ёс суртахууны асуудлыг төлөвшүүлэх зэрэг ялгаатай арга замуудыг хэрэглэж байв. Нөгөө талаас засгийн газрууд яагаад өсөлтийг дэмжих бодлогыг сайшаасан бэ? Хэдийгээр уг асуудлыг энд хэлэлцүүлэх нь зүйн хэрэг боловч үүний шалтгаанууд нь өөр хоорондоо ялгаатай юм.

Нацист Герман шиг эсвэл Израйл шиг Марксист дэглэмтэй зарим улсууд эрх мэдэл, үндсээрхэг үзэл болон улс төрийн үзэл суртлаа хамгаалахын тулд үзэл суртлын шалтгаантай холбоотойгоор бодлогоо хэрэгжүүлэхийг оролддог. Түүнчлэн, гэр бүл болон төрөлтийг хянахтай холбоотой Католик, Ислам шашны сүсэг бишрэл нь бодлого хэрэгжүүлэх бас нэгэн өдөөгч хүчин зүйл болж байдаг.

Баруун Европын нэлээд улс орнууд хөдөлмөрийн нөөцийг нэмэгдүүлэх болон хүн ам зүйн ачааллыг бууруулах чухал бодлогуудыг дэмжиж байсан. Бусад улс орнууд жишээлбэл, Франц (1920 онд) цэрэг дайны зорилгоор, нацист Герман газар нутгийн ноёрхол болон арьсны дээд үзэлтэй холбоотойгоор төрөлтийг дэмжих сонирхолд хөтлөгдөж байжээ. Тэр үед мөн “Дээд угсаа” гэсэн ойлголтыг нэвтрүүлэх улс төрийн үзэл суртал хүчтэй өрнөж байсан юм.

## **ӨСӨЛТИЙГ ДЭМЖИХ БОДЛОГУУДЫН БИЕЛЭЛТҮҮД**

Төрөлтийг дэмжих байдлаар хүн амаа өсгөх бодлогууд нь хэр зэрэг амжилттай хэрэгжиж байсан бэ? Судалгаануудын үр дүнгээс харахад энэхүү бодлогын зорилгод хүрч чадахуйц олон нийтийн шийдвэр, санал нэгтэй байр суурь тухайн үед бүрэлдээгүй байжээ. Тиймээс төрөлтийн үр нөлөөгөөр биелэх бодлогын биелэлтийн цар хүрээ хязгаарлагдмал байв. Үүнийг ерөнхийд нь уг бодлогыг хэрэгжүүлэхийг оролдож байсан улс орнуудын хувьд үр ашиг нь тэг эсвэл өчүүхэн бага байсан гэж хэлж болно. Энд хоёр зүйлийн талаар тодруулбал, 1930-аад оны үеийн нацист Германы бодлого, 1920-оод оны үеийн Францын бодлогыг авч үзье.

Нацист Герман 1930-аад оны үед төрөлтийг өсгөхөд чиглэсэн маш түрэмгий бодлого баримталж байсан тухай өмнө нь дурдсан билээ. Энэхүү бодлогын үндэслэл нь ерөнхийдөө арьсны дээд үзэл болон газар нутгийн ноёрхол тогтооход “Дээд угсаа”-г бий болгох явдал байв. Тэр үед авч хэрэгжүүлж байсан арга хэмжээнүүд нь түлхэх эсвэл урам өгөх хүчин зүйлүүдэд үндэслэн бодлогынхoo амжилтыг батлахыг оролдож байсан нь гарцаагүй.

Энд үр хөндүүлсэн эмэгтэйчүүдийн талаархи эрүүгийн шийтгэл, жирэмснээс сэргийлэх хэрэгслийн тухай мэдээллийг нуух, насанд хүрсэн гэрлээгүй хүмүүст ногдуулах татвар, залуу хосууд хүүхэдтэй болбол тэдэнд олгосон хуримын зээлийн тодорхой хэсгийг хэрэгсэхгүй болгох, гэр бүлийн тэтгэмжүүд, өнөр гэр бүлийн хувьд татварын хөнгөлөлтүүд, байрны хөнгөлөлт,

түүнчлэн “Дээд угсаа”-г сурталчлахыг эрмэлзсэн улс төрийн суртал нэвтрүүлэг зэрэг урамшууллын болон хязгаарлалтын арга хэмжээг авч байжээ. 1930-аад оны төрөлтийн үр ашиг нь юу байсан бэ? Төрөлтийн түвшин (1000 хүнд ноогдох) өсөж 1933 онд 14.7 байснаа 1934 онд 18.0, 1938 онд 19.7 болжээ. Бодлого нь хэдийгээр төрөлтийн түвшинг өсгөх тал дээр амжилт олсон боловч ихэнх үр ашиг нь ам бүлийн тоо хэмжээг бүрэлдүүлэх гэсэн ялихгүй үр нөлөөтэй эрт гэрлэлт болон анхны төрөлт байсан юм.

Францад 1920 онд төрөлттэй холбоотой хууль тогтоол хүчин төгөлдөр болжээ. Тэр үед үр хөндөлт, жирэмснээс хамгаалах хэрэгслийн худалдаа болон төрөлтийг зохицуулахтай холбогдсон мэдээллүүдийг хориглох зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхийг оролдож байв (1960-аад оноос хойш уг хуулийг хүчингүй болгожээ).

Бүх яамд хүн амын хороо/комисстой байсан байна. Санхүүгийн урамшуулал нь хүүхэдтэй гэр бүлүүд, гэртээ үлдсэн (хүүхдээ хараад) эхчүүдэд зориулсан тусгай төлбөр, түүнчлэн олон ам бүлтэй өрхийн тэтгэмжүүдэд олгогдож байлаа. 1950 онд З хүүхэдтэй өрхүүдэд зориулан олгож байсан тэтгэмжийн хэмжээ нь улсын дундаж цалингийн хэмжээнээс их байв. Хэдийгээр нийгэм, эдийн засгийн бусад өөрчлөлтүүдийн үр нөлөөнөөс салгаж авч үзэхэд хэцүү боловч хууль тогтоох арга хэмжээ нь Францын төрөлтийн түвшинг 10 хувь (нэг эмэгтэйд 0.2 хүүхэд) өсгөсөн байж болох юм.

Энэ нь голдуу арга зүйн хүрээнд шүүмжлэгддэг. Учир нь нэгдүгээрт: хэд хэдэн хүчин зүйлсийг тогтмол байх талаар том таамаглалыг шаарддаг, хоёрдугаарт: Францын төрөлтийн түвшинг ойролцоо улс орнуудтай харьцуулсан харьцуулалт дээр үндэслэсэн юм. Бодлогын хэрэгжилтүүдийн талаархи судалгаанууд нь арга зүйн хувьд, ялангуяа мэдээллийн хамрах хугацаа болон энд авч үзээгүй судлах зүйлүүдийн хувьд бэрхшээлтэй асуудлуутай тулгарч байна.

Төрөлтийн түвшин доогуур байх үед төрөлтийн өөрчлөлт нь төрөлтийн үеүрэл дэх өөрчлөлттэй нягт холбоотойгоор өөрчлөгдөхгүй байх хэрэгтэй. Эндээс богино хугацааны ололт амжилт нь урт хугацаанд урьдчилан таамаглах ялихгүй боломжийг агуулж байдаг. Энэ нь тухайн бодлогын үйл ажиллагаа болон түүний ойрын хугацааны хүн ам зүйн үр дүнгийн хор уршгийн хоорондын холбоо хамаарлыг судлах сонирхлыг үгүй болгодог.

## МОНГОЛЫН ХҮН АМЫН ПРОНАТАЛИСТ БОДЛОГО

Хуучин социалист системийн улс орнуудын нэгэн адил Монгол улс нь 1980-аад оны эхээр хүн амын пронаталист бодлогыг дэмжиж байсан (НҮБ, 1982). 1996 онд батлагдсан Монголын хүн амын бодлогод хүн амын жилийн дундаж өсөлтийн хурдыг засгийн газар төлөвлөсөн хугацааны дагуу 2015-2020 он хүртэл жил бүр 1.8 хувиас бууруулахгүй тогтвортой байлгах зорилт тавьсан билээ. Сүүлийн арван жилийн хугацаанд хүн амын жилийн дундаж өсөлтийн хурд 1.4 хувь болтлоо буурсан юм.

## ХҮН АМ ЗҮЙН БАЙДАЛ

Монголын хүн амын пронаталист бодлогыг хялбархан ойлгохын тулд өнгөрсөн зуун дахь хүн ам зүйн зарим үзүүлэлтүүдийг ялангуяа, өсөлтийн хурд болон ТНК-ийг авч үзэх нь чухал юм.

Түүхчдийн үзэж байгаагаар Монголын хүн ам ХХ зуун эхлэхээс өмнө 300-аад жилийн турш буурсан ажээ. Өсөлтийн хурд нь 1950-аад он хүртэл маш алгуур байв. Ийнхүү аажмаар өсөж байсны зарим шалтгаанууд нь: 1911 оны ардын хувьсгалаас Дэлхийн II дайны хооронд Монголд болсон үйл явдлууд тухайлбал, ердийнхөөс өндөр нас баралт, хувьсгалын үеийн хүмүүсийн гадагш чиглэсэн шилжилт, дотоодын зөрчилдөөн болон 1930-аад оны улс төрийн хэлмэгдүүлэлтийн үеийн асар их гарз хохирол зэргээс улбаалан эдийн засаг тогтвортой байсантай холбоотой.

1930 онд өсөлтийн хурд дөнгөж 1 хувь байжээ. 1935-1944 онд өсөлтийн хурд дөнгөж 0.3 байсан бол 1944-1956 онд 0.9 болсон байна. Энэ нь 1956-1963 онд 2.6 хувь болж өсчээ. 1963-1969 онд өсөлтийн хурд 2.76 хувь байснаа өсөөд 1969-1979 онд 2.91 хувь болсон. Дарагийн арван жилд (1979-1989) энэ түвшин буурч 2.5 хувь болсон бөгөөд 1989-2000 онд өмнөх бууралтаас илүү хурдацтай буурсаар 1.4 хувь болоод байна. Энэ хугацаанд төрөлтийн түвшин мөн буурч байв. Төрөлтийн ерөнхий коэффициент (ТЕК) сүүлийн арван жилд мөн адил буурчээ. 1989 онд ТЕК 36.5 байсан бол 1999 онд энэ нь 40 хувиас 20.4 хувь болтлоо буурсан байна.

Монголын хүн ам зүйн байдлын талаархи судалгаануудаас харахад 1991 онд социалист систем задран унаснаас хойш хүн ам зүйн үзүүлэлтүүдэд гайхалтай өөрчлөлтүүд бий болжээ.

Шилжих хөдөлгөөн, түүнчлэн хүн амын өрдийн өсөлт нь энэ үйл явдлыг тодорхойлогч хүчин зүйлүүд болж байна. Судлаачдын үзэж байгаагаар төрөлтийн бууралт нь гол төлөв шилжилтийн үеийн бэрхшээлийг даван туулах явцад бий болсон зарим хүчин зүйл болох хүмүүсийн амьжиргааны түвшний доройтол, эмэгтэйчүүдийн жирэмснээс сэргийлэх хэрэгслийн хэрэглээний өсөлт болон 1990 онд үр хөндөлтийг хуулиар зөвшөөрсөн зэрэгтэй холбоотой. Нөгөө талаас гадагш чиглэсэн шилжих хөдөлгөөн нь нөлөө бүхий хүчин зүйл болж байна. 1989 оноос хойш гадагш чиглэсэн шилжилт нэмэгджээ.

Монголын олон мянган (60.000-аас илүү) казак үндэстнүүд хөдөлмөрийн гэрээгээр Казакстан руу явснаас гадна Монголд ажиллаж, амьдарч байсан хуучин ЗХУ-ын 50.000 орчим иргэн нутаг буцсан билээ. Мөн тэр үед маш олон залуучууд бусад улс орнуудад ажиллах болон суралцахаар явж байв. Энэ хөдөлгөөн нь Монголын хүн ам зүйн байдалд маш том цохилт болсон юм. Тэд 1989-2000 оны өсөлтийн түвшний эрчимтэй бууралтыг хариуцах уу? ТЕК-ийн талаар юу гэх вэ?

## АСУУДЛУУД БОЛОН ҮР ДАГАВРУУД

Эдгээр нь пронаталист бодлого ба түүний бодит хэрэгжилт эхлэхээс өмнөх үед яригдах асуудлууд болно. Бодлогыг зөв үндэс суурьтайгаар эхлэх болон амжилттай хэрэгжүүлэхийн тулд эдгээр асуудлуудыг авч үзэх нь чухал юм.

Монголын хүн амын пронаталист бодлого нь одоог хүртэл гүйцэд хөгжиж чадаагүй, учир нь энэхүү бодлого нь тодорхой өвөрмөц шинжгүй байна. Өргөн хүрээнд авч үзвэл хүн амын бодлого нь дээр дурдсанчлан бодлогын зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэсэн ямар нэг тусгай хөтөлбөргүйгээр аль хэдийн тодорхойлогдчихоод байгаа юм.

### **Бодлогын томъёолол:**

Асуудал 1. Пронаталист бодлого шаардлагатай гэсэн баталгаа байна уу? Хүн амын бууралтын талаар удирдлагын дээд түвшинд шинжлэх ухааны болон хүнд суртал бүхий үзэл бодлыг нэгтгэх засгийн газрын буюу парламентийн хороо байгуулагдсан уу? Энэ хороо нь хөгжлийн төлөвлөгөөний үндэс/эхлэл нь болох юм. Хүн амын өсөлтийн бууралтын урт хугацааны үр дагавар нь олон нийтэд тодорхой болсон уу? Эсвэл бууралт нь хүн ам зүйн үзүүлэлт, үр дүнд хөндлөнгөөс оролцох хангалттай шалтгаан мөн үү? Зарим санал/төлөвлөгөө нь улс төрийн үйл явцын хатуу сорилтыг давах ёстой төрөлтийн талаархи хүссэн үр дүнг амлаж болох тийм саналууд байдаг. Өнөөгийн Монгол шиг ардчилсан улсад энэ нь олонхийг дэмжих болон үндсэн хуульд заасны дагуу цөөнхийн үзэл, бодол, эрх ашгийг хамгаалах эрх мэдэлтэй байх ёстой. Монгол дахь үйл явц нь тэдгээр шалгууруудыг давж гарах хэрэгтэй.

Асуудал 2. Хүн амд, тэр дундаа сайд нарын хамтын ажлын хэсэгт хүн амын өсөлтийн бууралтын бодит үр дагаврудын талаархи мэдээллийг өгөх судалгаа хийгдсэн үү? Хүн амын өсөлтийн бууралт нь эдийн засаг, нийгэм, улс төрд ноцтой хор уршиг учруулж байсан тийм баримт нотолгоо бий юу? Хэрэв төлөв байдал нь шаардлага хангаж байвал, пронаталист бодлогыг дэмжих тохиролцоонд хүрсэн байж болох юм.

Асуудал 3. Магадгүй төрөлт нь пронаталист бодлогоор хөндлөнгөөс оролцох шаардлагагүй гэдгийг нотлохуйц дундаж нь хангалттай өндөр түвшинд байгаа хүн амын зарим дэд бүлгүүд тухайлбал, газар зүйн, нийгэм-эдийн засгийн, үндэстэн ястны шалгуураар тодорхойлогдсон бүлгүүдийн хувьд улсын чиг хандлага болон Монголын төрөлтийн түвшнийг илэрхийлсэн эргэцүүлэл нь бодлогогүй/зөвтгөх аргагүй зүйл болсон эсэхийг тодорхойлох судалгаа хийгдсэн үү?

Асуудал 4. Парламентийн гишүүд, түүнчлэн хүнд сурталтнуудын санал бодол, зөвлөгөөнд нь найдаж болох уу, бодлогын төсөл болон тайлан илтгэл бичигчид хүн ам зүйн нөхцөл байдлын нөлөөнд бүрэн дүүрэн итгэсэн байдаг уу? Тэдний дэвшүүлсэн саналууд/төслүүд нь магадгүй тэд тэнцүү эсвэл илүү ач холбогдолтой гэж авч үзсэн өвөрмөц хэмжигдэхүүнүүдээр хязгаарлагддаг уу? Бодлого боловсруулах хүрээний цөмд нь эсрэг тэсрэг үзэл адил тэнцүү хэмжээгээр зэрэгцэн оршдог уу?

Парламентийн гишүүд болон гүйцэтгэх хүнд сурталтангуудын хоорондын зөвшилцөл нь хүн амын пронаталист бодлогын хэрэгжилтийн амжилтанд маш чухал юм.

Ил тод эсвэл нууц сөрөг хүчнийхэн хэрэгжилтийн явцыг дордуулдаг. Хэрэгжилтийн байдлыг хянахын тулд тийм бодлогыг дэмжигчид нь нөлөө бүхий, тодорхой хариуцлага хүлээсэн албан тушаалд байх нь чухал. Хүн амын пронаталист бодлогыг хэрэгжүүлэхийг оролдож байгаа зарим улс орнуудын

нийгэмд тогтсон ёс заншилд нь эсрэг тэсрэг үзэл зэрэгцэн оршиж байх нь хөтөлбөрийн зорилгуудын амжилт, ололтыг нураадаг.

Асуудал 5. Залуучууд, эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд нь илүү олон хүүхэдтэй болохыг хүсдэг үү? Хэрэв залуу үеийнхний дунд хүүхэдтэй болох туштай хүсэл байвал пронаталист бодлого нь амжилтанд хүрэх боломжтой болно. Эмэгтэйчүүдийн хувьд жишээлбэл, хүүхдүүдийнхээ тоог хязгаарлагдсан байхыг тэд хүсэх болов уу? Олон нийтийн дэмжлэг нь бодлогын зорилтуудад хүрэхэд хэрэгцээтэй чухал зүйл юм.

Асуудал 6. Төрөлт гэж юу болох, түүний ирээдүйн хандлага нь хаашаа чиглэж байгаа болон Монголд энэ асуудлыг яагаад авч үзэж байгаа бид хэр зэрэг сайн ойлгодог вэ? Хэдийгээр пронаталист бодлого нь сайн төлөвлөгдсөн боловч үнэндээ төрөлтийг тодорхойлогч хүчин зүйлсийн талаархи хангалттай мэдлэггүйгээс энэ нь магадгүй жолоодлогогүй явж байж болох юм. Монгол дахь гоц үзэгдлийг бодлого боловсруулагчдад зориулан үеэс үед хийгдэж байдаг ухаалаг зөвлөмжүүдэд үндэслэн тайлбарлах мэдлэгийн хангалттай нөөц байнга шаардагдаж байна. Төрөлтийн түвшний аяндаа бий болсон ирээдүйн хандлагын талаарх шинжээчдийн, хүн ам зүйн санал бодол үргүйлэгдэж байгаа нь төрөлтийн түвшин нь эргэн нөхөгдөх түвшин рүүгээ эргээд нэмэгдэхийг батлах эсвэл буурах хандлага үргэлжилсээр байх боломжийг үл тоомсорлох байр суурьтай хүн байхгүй байгааг илтгэж байна.

Асуудал 7. Зах зээлийн эдийн засагт шилжин орсны үр дагаврууд төрөлтийн байдалд нөлөөлж байна уу, тийм бол хэрхэн нөлөөлж байна вэ? Бүтцийн өөрчлөлт нь дотоодын эдийн засагтай холбоотой эдийн засгийн таагүй уур амьсгал ялангуяа, татварын дараахи орлогын асуудал дээр, мөн тогтвортой байдал болон хүүхдэд хандах хандлагын тал дээр аль хэдийн хор нөлөө учруулчихаад байна уу? Эцэст нь, үргэлжилсэн судалгаанууд нь тэд пронаталист бодлогыг дэмжих эсвэл дордуулж болох цар хүрээнд тэдгээр асуудлуудыг нягталж үзэх оролдлого хийхийг шаарддаг юм.

## ХЭРЭГЖИЛТ

Асуудал 8. Хүн амын пронаталист бодлогын кампанит ажлыг тэргүүлж байгаа гэр бүл/хүн амын хэрэг эрхлэх газар, ерөнхийдөө засгийн газрын тогтолцоо нь хэр хүчтэй, мэдэгдэхүйц байdag вэ? Нэлээд улс орнуудад хүн амын яамдууд нь гол төлөв өргөн хүрээний асуудал хариуцсан сайдуудаар удирдуулдаг. Тийм нөхцөл байдалд тэд ерөнхий бодлогыг баримтлахын тулд тохируулсан эсвэл аль нэг хэлтэст танилцуулсан хэмжүүрүүд нь зөрчилдөх зэргээр зарим төлөвлөгөөний гол фокус төв нь алдагддаг. Энэ төрлийн үйл ажиллагаа нь хүн амын бодлогын эмх цэгцгүй байдал, түүнчлэн пронаталист бодлогоор төлөвлөж байснаас ч илүү сул дорой хүн ам зүйн нөлөөллийг үзүүлдэг.

Дорой байдал гэдэг бол хүн амын асуудал хариуцсан яамдууд нь засгийн газрын хүчийг төвлөрүүлэх боломж тааруухан бөгөөд засгийн газрын бусад агентлагуудын үйл ажиллагааг зохион байгуулах эсвэл түүнд нөлөөлөх бага зэргийн чадвартай байна гэсэн үг юм. Ийм төрлийн зохицуулалт нь хүн амын бодлогын томъёололд чухал төдийгүй хүн ам зүйн хандлагууд нь засгийн газрын эдийн засгийн бодлогын зарим хэсгийг алгасах эсвэл хасах нөхцөлтэйгөөр

нэлөөлөх болсноос хойшхи хэрэгжилтэнд чухал байдаг. Тухайлбал, цагаачлал ба хууль бус ажил эрхлэлтийг энд дурдаж болно. Тийм учраас зохицуулалтын асуудал нь маш төвөгтэй.

Энэ нь Монголын бодлого боловсруулагчид бий болсон нөхцөл байдлыг үнэлэх, түүнчлэн хэрэв пронаталист бодлого амжилттай бол түүний хэрэгжилтэд хамгийн сайхан уур амьсгал бүрдүүлэх үүрэг хариуцлагын асуудал болно.

Асуудал 9. Пронаталист бодлогын үндсэн ачааллыг тэнцвэржүүлж буй эмэгтэйчүүдэд хүндэтгэлтэй хандсанаар амжилтанд хүрсэн ямар нэг бодлого байна уу? Жишээ нь, ажил болон өрх гэрт хоёр хүйсийн хоорондын тэнцвэржилтэнд хүрэхэд чиглэсэн бодлого. Ийм бодлогууд нь голдуу эмэгтэйчүүдэд хүүхэд төрүүлэхтэй холбоотой эрх чөлөөг илүү их бие даасан, хараат бус байдлаар олгодог. Тиймэрхүү бодлогууд нь пронаталист бодлогын хүрэхээр төлөвлөж бий зорилтуудыг биелүүлэхэд дэмжлэг болох байдлаар илэрхийлэгдэж, харагдаж байвал зохимжтой. Бодлого боловсруулагчид нь пронаталист бодлоготой зөрчилдөж болзошгүй өмнө нь батлагдан гарсан бодлогуудыг тооцож үзэх шаардлагатай.

Асуудал 10. Уламжлалт гэр бүлийг ухуулан сурталчлах улс төрийн лобби бий юу? Монгол улс зах зээлийн эдийн засагт шилжсэнээр хувь хүний эрх чөлөө нэмэгдсэн. Эдгээрийн зарим нь нөхөн үржихүйн чухал нэгж болох уламжлалт гэр бүлийн үнэ цэнийг дордуулж болно. Тийм нөхцөл байдалд уламжлалт гэр бүлийг сурталчилсан улс төрийн лобби нь пронаталист бодлогын амжилтанд чухал шаардлагатай байж болох юм. Уламжлалын бат бөх байдал нь Монголд задраагүй хадгалагдсан хэвээр байгаа юу, эсвэл сонирхол нь уламжлалт гэр бүлээс ялгаатай ганц бие, салсан болон гэрлээгүй гэр бүлүүдийн бүх төрлийг ойлгох/нэвтрүүлэх болсон уу? Гэр бүлийн эрэлт, хэрэгцээг тодорхойлсон гэр бүлийн нийгэмлэгийн сүлжээ байх нь чухал. Хэрэв тэд уламжлалт гэр бүлийг сурталчилсан нөлөө бүхий лобби зохион байгуулбал тийм байгууллагуудын эв нэгдэл нь маш чухал болно.

Асуудал 11. Хөдөлмөрийн зах зээл болон цагаачлалын бодлого Монголын пронаталист бодлогын аль сэдвийн хүрээнд байвал зохих вэ? Санaa нь эцэг эх болох, ажил эрхлэх эрэлтийг тэнцвэржүүлэх, түүнчлэн эцэг, эхийн үүрэг хариуцлагаар нь ажиллах орчинг таатай болгоход чиглэх хэрэгтэй. Ирээдүйд монголд нэг удаагийн ялангуяа, ээжүүд болон аавуудад урам өгөхтэй холбоотой хөтөлбөр хэрэгжиж эхлэх бөгөөд ажлын нөхцөл байдлыг сайжруулахад анхаарлаа хандуулахыг шаардах болно. Иймээс гэр бүлийн сонирхлыг судлах нарийн зохион байгуулагдсан салбар бүхий ажил олгогчид болон ажилчдын холбоотой байхыг шаардах болно. Тэр нь төлөвлөгөөнүүд, тухайлбал, жирэмсний амралтыг шийдвэрлэх чадвартай байх ёстой. Цагаачлал нь Монголын ялангуяа, зах зээлийн эдийн засагт шилжин орсноос хойшхи үеийн хүн ам зүйн чухал үзэгдэл юм. Дотоод болон гадаад шилжих хөдөлгөөн хоёулаа нэмэгдсэн. Эцсийн үр дүндээ энэ нь цагаачлалын бодлогоор хууль ёсны болсон. Энэ нь хүн амын бодлогын нэг хэсэг мөн үү? Одоо шилжих хөдөлгөөний асуудал нь хууль тогтоох байгууллагаар хянагдаж байна. Шилжих хөдөлгөөн нь байж болох эдийн засаг, нийгмийн чадвар, тохиромжтой байдлыг үнэлэхийн тулд, гэхдээ доогуур төрөлтийн түвшний нөхөн төлбөрийт уриалахгүйгээр хянагдах хэрэгтэй.

Асуудал 12. Бодлогод дэд бүтэц, орон сууц ямар байдлаар орсон бэ? Энэ нь төсвийн болон байгууллагын алиных нь байх хэрэгтэй. Монголд пронааталист бодлогын хүчтэй кампанит ажлыг бий болгохын тулд байгууллагын дэд бүтэц байх хэрэгтэй. Засгийн газар өрхөд санхүүгийн дэмжлэг үзүүлэх үед бодлогыг дэмжих төсвийн хуваарилалтыг авч хэлэлцэх хэрэгтэй болно. Засгийн газрын нийгмийн тогтолцоо, хүн ам зүйн бодлого нь санхүүжилтийн төлөө бусад хөтөлбөрүүдтэй өрсөлдөх ёстой.

Асуудал 13. Засгийн газарт пронааталист бодлогод зориулсан байгууллагын зохицуулалт хангалттай байдаг уу? Зарим засгийн газрын хэд хэдэн бодлого, хөтөлбөрүүд нь үр ашигтай зохицуулалтын механизм дутагдсанаас үр дүнгүй болсон. Пронааталист бодлогыг хэрэгжүүлж буй Монгол улсын хувьд зохицуулж буй байгууллага нь бодлогын үр дүнг доройтуулж болох янз бүрийн сонирхолгүй гэдэгт баталгаа өгөх нь чухал юм.

Асуудал 14. Гэр бүлд хүүхэд төрүүлэхийг нь дэмжих санхүүгийн урамшууллыг хангах болон 1970-аад оноос хойш засгийн газраас дэмжиж ирсэн бусад арга хэмжээнүүд тухайлбал, эцэг эх болон хүүхдүүдийн хэрэгцээнд илүү нийцүүлэн нийгмийн орчинд чиглэгдсэн арга хэмжээнүүдэд хэр зэргийг зарцуулах шаардлагатай байна вэ?

Эдгээр нь хотын захад байрлалтай амралтын чадавхийг хангах; гэр болон хүүхэд өдрөөр асрах төвийн хооронд илүү сайн нийтийн тээврийг бий болгох, худалдааны бүс, бага насны хүүхэдтэй эцэг эхчүүдийн ажлын цаг болон нөхцлийг сайжруулах, цалингаа хасуулахгүйгээр өвчтэй хүүхдээ гэртээ асрах, мөн бусад адил төстэй арга хэмжээнүүдэд чиглэгдэнэ. Энд байгаа зорилт нь туршлагатай улс орнуудад тулгарч байсан асуудлуудыг багасгах явдал юм.

Тиймээс Монгол улс эдгээр арга хэмжээнүүдтэй холбоотой томъёоллыг шинжлэн бусад улс орнуудаас суралцах хэрэгтэй.

## НОМ ЗҮЙ:

1. Population Policy of Mongolia, 1996, UlaanBaatar, Mongolia, Government of Mongolia, 1996.
2. Mongolia Population and Housing Census 2000-Main Results, NSO,
3. Population and Development Review-Supplement to vol. 12, 1986 "Below Replacement in Industrial Societies: causes, consequences, policies.1986
4. "Recent pro-natalist policies in W. Europe" 1986 –C.Alison Mackintosh
5. "Pro-natalist policies in low-fertility countries: patterns, performance and prospects", 1986, Paul Demeny
6. Population Policy Website-geography.ac.uk.courses/geog/272/cohp6.html
7. Fertility Decline, Below Replacement Fertility and the Family in Asia: Prospects, Consequences and Policies-National University of Singapore, Proceedings of Workshop 10-12 April 2002